



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/106

Булган сум

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Музейн барилгын засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

О.Буянбат (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Эрдэнэтуяа (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

